



“ГУТАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

Улаанбаатар-17043
ХУД, 2-р хороо
Чингисийн өргөн чөлөө
“Гутал” ХК

Утас: 976 -11 - 342637
Факс: 976 -11- 343267
Вэб сайт: www.gutalco.mn
Э-шуудан: gutal.company@gmail.com

Огноо 2017.03.10

Дугаар 13

Улаанбаатар хот

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь хэсэг, 80 дугаар зүйлийн 80.2 дахь хэсэг, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэг, “Гутал” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.31.15 дахь хэсэг, 2017 оны 03 дугаар сарын 10-ний өдрийн “Гутал” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Гутал” ХК болон “Нурамт Холдинг” ХХК хоорондын сонирхлын зөрчилтэй хэлцлүүд болох үл хөдлөх хөрөнгө худалдах худалдан авах гэрээ, газрын эзэмших эрх шилжүүлэх гэрээнүүдийг байгуулахыг зөвшөөрсүгэй.
2. “Гутал” ХК-ийн өмчлөлийн Хан-Уул дүүргийн 2 дугаар хороо 100 дугаар цех хаягтай 2922.2 мкв талбайтай өмчлөх эрхийн 000151974 тоот гэрчилгээтэй үл хөдлөх хөрөнгийг эзэмшил газрын хамтаар “Нурамт Холдинг” ХХК-д худалдах, байгуулагдах бусад гэрээнүүдэд гарын үсэг зурах эрхийг Ерөнхий захирал Ц.Төмөрт олгосугай.
3. Дээрх үл хөдлөх хөрөнгө худалдах худалдан авах гэрээ, газрын эзэмших эрх шилжүүлэх гэрээнүүдийг хавсралтаар баталсугай.
4. “Кашмир концепт” ХХК-ийн “Гутал” ХК-д төлвөл зохих 497,176,576 төгрөгийн шаардах эрхийг үл хөдлөх хөрөнгийг газрын хамтаар шилжүүлэх гэрээ байгуулахтай холбогдуулан “Нурамт Холдинг” ХХК-д шилжүүлэхийг Ерөнхий захирал Ц.Төмөрт зөвшөөрсүгэй.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

БАМАРСАНАА

